



ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2019.04.08-04.12

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд бага хэмжээний өсөлт үзүүлээ. S&P 500 индексийн сагсанд багтаж буй банк санхүү болоод харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа явуулдаг компаниудын хувьцааны ханш өссөн бол эрүүл мэндийн салбарын компаниудын хувьцааны ханш буурсан үзүүлэлттэй байна.

Томоохон банк болох “JP Morgan” компанийн 1-р улирлын цэвэр ашиг урьдчилан таамаглаж байсан хэмжээг илт давж, тус компанийн хувьцааны ханш өссөн бол “Walt Disney” компани кино үзвэр цацах үйлчилгээтэй болж байгаатай холбоотойгоор компанийн хувьцааны ханш өслөө. Харин эрүүл мэндийн салбарын томоохон төлөөлөл болох “Anthem” болон “UnitedHealth” компаниудын хувьцааны ханш унасан байна.

“Reuters” болон “FactSet” агентлагийн мэдээлснээр энэ оны 1-р улиралд нийт хувьцаат компаниудын ашиг өмнөх оны мөн үетэй харьцуулахад бага зэрэг буурчээ. Үүнд, эрчим хүчний салбарын зогсонги байдал болоод дэлхийн эдийн засгийн удаашрал нөлөөлсөн хэмээн шинжээчид үзэв.

АНУ Европын 11 тэрбум ам.долларын импортод тариф ногдуулж магадгүй талаар мэдээлэл гарч, хөрөнгийн зах зээлд сөргөөр нөлөөлжээ.

Европ: Европын бүсийн хөрөнгийн зах зээлийн STOXX Europe 600 индекс буурав.

Их Британи, Европын Холбоо “BREXIT”-ийн товыг энэ оны 10-р сарын 31 хүртэл хойшлуулахаар тохиролцсон гэж Европын зөвлөлийн Ерөнхийлөгч Дональд Туск мэдэгдлээ. Энэ нь хэлэлцээргүй “BREXIT”-ээс сэргийлэх зорилготой төлөвлөгөөний дагуу авах алхам юм байна. Хэдий тийм боловч энэхүү тохиролцоо дахин зургаан сарын хугацаанд улс төрийн тодорхойгүй байдал үргэлжлэх нөхцөлийг бүрдүүлж мэдэхээр байна. Нөгөө талаас ирэх 6-р сард талууд төлөвлөгөөний хэрэгжилтийг нягтлахаар тохиролцжээ. “BREXIT”-ийн тодорхойгүй байдлаас шалтгаалан хөрөнгө оруулагчид Их Британийн хөрөнгө оруулалтын сангуудаас хөрөнгөө татаж эхэлсэн ба тэд нийт 304.5 сая ам.долларын сангуудаас гарган авчээ.

Италийн Засгийн газар 2019 оны эдийн засгийн урьдчилсан таамгаа бууруулсан хэдий ч хөрөнгийн зах зээлийн индекс өсөлттэй хаагдлаа. 2019 онд тус улсын эдийн засаг 0.2 хувиар өснө хэмээн үзэв.

Япон: Японы хөрөнгийн зах зээлийн Nikkei 225 индекс 0.3 орчим хувиар өслөө.

ОУВС 2019 онд Япон улсын эдийн засгийн өсөлтийн таамагийг 1.1 хувиас 1.0 хувь болгон бууруулав. Энэ тус улсын экспортын хэмжээ эрс буурсан, дэлхийн эдийн засгийн өсөлт удааширсантай холбоотой ажээ.

БНХАУ: АНУ болон БНХАУ хоорондын худалдааны хэлэлцээр эцсийн шатандаа орж байгаатай холбогдуулан БНХАУ-ын хөрөнгийн зах зээлийн индекс өсөлттэй байв.

Эх сурвалж: Reuters, Troweprice

Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	20,010.13	-0.49% ▼
Dow Jones	АНУ	26,412.30	-0.05% ▼
S&P 500	АНУ	2,907.41	0.51% ▲
Nasdaq	АНУ	7,984.16	0.57% ▲
S&P/TSX	Канад	16,480.53	0.51% ▲
FTSE 100	Их Британи	7,437.06	-0.13% ▼
S&P/ASX 200	Австрали	6,251.30	1.13% ▲
Nikkei 225	Япон	21,870.56	0.29% ▲
Hang Seng	Хонг Конг	29,909.76	-0.09% ▼

Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	111.14
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	99.28
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	99.19
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	110.81
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	104.60
DBM' 2023	USD	7.250%	103.75
TDBM' 2020	USD	9.375%	104.29

Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	2.470	0.00 ▼
Libor 3M	2.600	0.01 ▲
Libor 6M	2.640	0.00 ▼
Libor 1YR	2.748	0.00 ▼
US 2YR Bond	2.391	0.07 ▲
US 3YR Bond	2.356	0.08 ▲
US 5YR Bond	2.372	0.08 ▲
US 10YR Bond	2.558	0.07 ▲

Валютын ханш /төг/

Валют	2019.04.12	Өөрчлөлт
USD	2,631.77	0.01% ▲
CNY	391.71	-0.01% ▼
EUR	2,970.87	0.55% ▲
RUB	40.79	1.42% ▲
KRW	2.31	0.00% ▲
JPY	23.53	-0.13% ▼
CAD	1,970.18	-0.02% ▼

Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /spot/	USD/t oz.	1,290.43	-0.10% ▼
Мөнгө /spot/	USD/t oz.	14.97	-0.89% ▼
Зэс	USD/lb.	294.60	1.78% ▲
Нүүрс	USD/MT	87.13	7.83% ▲
WTI газрын тос	USD/bbl.	63.89	1.28% ▲
Brent газрын тос	USD/bbl.	71.55	1.72% ▲
Байгалийн хий	USD/MMBtu	2.66	0.00% ▼

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2019. II	6.90%
Бодлогын хүү	2019. II	11.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2019. II	11.00%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2019. II	12.00%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2019. II	5.30%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2019. II	17.00%
Зээлийн дундаж хүү /валют/	2019. II	10.70%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 40 компанийн 353.0 сая төгрөгийн 1,839,367 ширхэг хувьцаа арилжигдав.


“Түмэн шувуут” /TUM/ компанийн хувьцаа 12.40%-аар буюу хамгийн ихээр өсч 196.7 төгрөгт хүрч хаагдсан бол “Фронтинер лэнд групп” /MDR/ компанийн хувьцаа 15.00%-аар буурч 170.0 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

ЗГҮЦ-ны зах зээл дээр нийт 9,564 ширхэг үнэт цаас 981.6 сая төгрөгөөр арилжаалагдсан байна.


4-р сарын 12-ний өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,348.3 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 20,010.13 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.49%-аар буурсан байна.

MSE Индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2019 он/



*2018 оны 12-р сарын 31-ний өдрийн арилжааг хасан тооцсон

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	1,334.6
Зах зээлийн үнэлгээ	2,348,261.9

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	20,010.13	-0.49% ▼
MSE I индекс	9,015.59	1.79% ▲
MSE II индекс	8,186.49	0.48% ▲

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
АПУ	126,006	74,320,358
Говь	153,617	45,229,586
Ард кредит ББСБ	434,222	34,342,335
Түмэн шувуут	190,955	34,243,408
ЛэндМН ББСБ	479,703	31,575,733

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Түмэн шувуут	196.70	12.40% ▲
Нийслэл өргөө	5,900.00	11.32% ▲
МИК Холдинг	11,500.00	7.38% ▲
Женко тур бюро	70.62	5.40% ▲
Монгол базальт	249.01	3.97% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Фронтинер лэнд групп	170.00	-15.00% ▼
Монгео	17,850.00	-15.00% ▼
Нако түлш	97.75	-15.00% ▼
Монгол керамик	18,040.00	-14.99% ▼
Монгол савхи	510.00	-11.61% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Мирэ Эссет Секьюритис Монгол	1,667,076,010
Новел инвестмент	350,099,577
Голомт капитал	178,874,689
Ти Ди Би Капитал	84,750,303
Би Ди Сек	79,207,547

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	591.66	629,634
Таван толгой	6,400.00	337,057
МИК	11,500.00	238,157
Говь	295.70	230,679
Сүү	206.67	71,094

ЗГҮЦ-НЫ ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
1	ZGEB-BD-09/05/19-A0242-15.995	3,588	359,720,920	100,200	100,330	104	15.995%
9	ZGEB-BD-22/05/20-A0248-15.87	5,976	621,862,560	103,360	104,940	156	15.870%

НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	Симбол	Компанийн нэр	2018 оны цэвэр ашиг /сая төг/	Нийт хуваарилах ногдол ашиг /сая төг/	Ногдол ашиг төлөлтийн харьцаа	Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр
1	HRM	Гермес центр ХК	783.4	298.5	38.1%	3.8	2019.01.25	2019.02.18	2019.03.18-нд олгов
2	LEND	ЛэндМН ББСБ	2,560.3	800.0	31.2%	1.0	2019.01.30	2019.02.22	2019.03.28-нд олгов
3	MBW	Монгол Базальт ХК	217.2	56.4	26.0%	1.0	2019.02.01	2019.03.25	2019.10.01-с
4	BTG	Баянтээг ХК	1,771.4	1,000.0	56.5%	3,958.7	2019.02.11	2019.03.04	2019.06.01-с
5	SUL	Жуулчин дютри фрий ХК	1,384.5	653.6	47.2%	10,000.0	2019.02.12	2019.04.10	2019.05.31-с
6	GOV	Говь ХК	17,764.2	5,304.8	29.9%	6.8	2019.02.13	2019.03.28	2019.04.25-с
7	ADU	Хөвсгөл алтан дуулга ХК	399.2	1,888.1	473.0%	120.0	2019.02.13	2019.04.01	2019.05.01-с
8	TCK	Талх чихэр ХК	1,975.9	204.7	10.4%	200.0	2019.02.14	2019.04.03	2019.07.01-с
9	MMX	Мах импекс ХК	778.6	456.1	58.6%	120.0	2019.02.14	2019.04.03	2019.10.01-с
10	BUK	УБ-БҮК ХК	566.4	131.5	23.2%	1.0	2019.02.14	2019.04.05	2019.05.01-с
11	ТАН	Тахь-ко ХК	799.1	128.5	16.1%	108.0	2019.02.15	2019.04.05	2019.05.01-ний дотор
12	BNG	Баянгол зочид буудал ХК	3,433.1	150.2	4.4%	355.0	2019.02.16	2019.04.05	2019.09.01-с
13	MNP	Монгол шуудан ХК	1,560.3	468.1	30.0%	4.7	2019.02.18	2019.04.05	2019.05.01-с
14	HRD	Хүрд ХК	751.1	74.4	9.9%	550.0	2019.02.18	2019.03.04	2019.06.01-ний дотор
15	MNDL	Мандал даатгал ХК	3,868.3	624.3	16.1%	100.0	2019.02.18	2019.04.10	2019.05.01-с
16	GTL	Гутал ХК	2,225.8	1,257.7	56.5%	777.0	2019.02.18	2019.03.13	2019.05.06-с
17	TEX	Техник импорт ХК	2,702.0	723.4	26.8%	500.0	2019.02.18	2019.03.11	2019.04.11-с
18	APU	АПУ ХК	57,851.7	48,952.4	84.6%	46.0	2019.02.19	2019.04.04	2019.12.31-ний дотор
19	AIC	Ард даатгал ХК	1,263.4	631.8	50.0%	25.3	2019.02.19	2019.03.15	2019.06.29-ний дотор
20	GHC	Ган хийц ХК	20.3	12.1	59.7%	50.0	2019.02.19	2019.03.22	2019.10.01-с
21	HUV	Хөвсгөл геологи ХК	107.4	14.4	13.4%	100.0	2019.02.19	2019.04.03	2019.04.29-с
22	HNS	Хөвсгөл хүнс ХК	11.3	2.6	23.4%	10.0	2019.02.19	2019.04.03	2019.05.15-с
23	TAL	Талын гал ХК	255.9	34.7	13.6%	50.0	2019.02.25	2019.03.26	N/A
24	BRC	Барилга корпораци ХК	1,311.0	40.1	3.1%	985.0	2019.02.26	2019.03.18	2019.03.18
25	UBH	Улаанбаатар хивс ХК	235.6	48.6	20.6%	120.0	2019.02.26	2019.03.18	2019.05.31-ний дотор
26	DSS	Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХК	11.5	11.4	99.2%	1.1	2019.03.01	2019.03.21	2019.07.02-с
27	ADL	Адуунчулуун ХК	547.1	409.7	74.9%	130.0	2019.03.11	2019.04.03	2019.12.31-ний дотор

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

“Эрдэнэ ресурс девелопмент корпорэйшн”-ийн хувьцаа эзэмшигчдийн анхааралд

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн (TSX:ERD | MSE:ERDN) нь Хөндий Алтны Төслийн 2019 оны өрөмдлөгийн ажиллагааг эхлүүлсэн байна. Тус ажиллагааны нэгдүгээр үе шатанд 1,800 метрийн гүнд өрөмдлөг хийх бөгөөд олон улсын инженерчлэлийн Tetra Tech компанийн боловсруулж буй урьдчилсан ТЭЗҮ-д тусгагдах мэдээллийг баталгаажуулах, Баян Хөндий ордыг тэлэх, өндөр агуулга бүхий нөөцийг баталгаажуулан шалгахад чиглэгдэх бол хоёрдугаар үе шатанд энэ оны сүүлээр хийгдэх бүс нутгийн хэмжээний хайгуулын үйл ажиллагаа төлөвлөгдсөн байна.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Талх чихэр” ХК 2019 онд “Ургац”, “Unimax” шугамын хүчин чадлыг нэмэхээр зорьж байна

“Талх чихэр” ХК 2019 онд “Ургац”, “Unimax” шугамын хүчин чадал, ашиглалтыг нэмэгдүүлэх, лабораторийн тоног, төхөөрөмжийг сайжруулах зорилттой ажиллаж байгаагаа тайландаа онцолсон байна.

2018 онд тус компани 100 гаруй нэр төрлийн 14 мянган тонн бүтээгдэхүүн борлуулж, 46.6 тэрбум төгрөгийн орлого олжээ. Ингэснээр 1.9 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна. Мөн гурил, элсэн чихэр хүлээн авах, хадгалах, дамжуулах системийг суурилуулж, үйлдвэрлэлд нэвтрүүлэн, шинээр “Онцгой” брэндийн бүтээгдэхүүнийг худалдаанд гаргаж, шугамын хүчин чадлыг нэмэгдүүлжээ.

Үүнээс гадна үзэмтэй талх, “Хлем” буриад талх, загасан талх, олон үртэй хөх тарианы саримстай багет зэрэг бүтээгдэхүүнийг шинээр зах зээлд гаргасан байна. Хүний нөөцийн бодлогын хүрээнд “Талх чихэр” ХК ажилчдаа зориулсан “Хотол” орон сууцны хөтөлбөр хэрэгжүүлж байгаагаа тайландаа тусгажээ.

Эх сурвалж: BloombergTv.mn

МХБ: 12 ХК II улиралд багтан ногдол ашгаа тараана

Монголын Хөрөнгийн биржид бүртгэлтэй 12 компани энэ улиралдаа багтан хувьцаа эзэмшигчдэдээ 2018 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах товтой байна. Тухайлбал, “Техник импорт”, “Говь” компани энэ сард ногдол ашгаа хуваарилах төлөвлөгөөтэй байгаа бол “Мандал даатгал”, “Хөвсгөл алтан дуулга” зэрэг компаниуд ирэх сард ногдол ашгаа тараахаар зорьж байна.

Одоогоор Монголын Хөрөнгийн биржид 27 компани ногдол ашиг тараах шийдвэрээ танилцуулж, хувьцаа эзэмшигчдэдээ нийт 64.4 тэрбум төгрөг хуваарилахаар болоод байгаа юм. Эдгээрээс “ЛэндМН ББСБ” ХК болон “Гермес центр” компаниуд Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан ногдол ашгаа хувьцаа эзэмшигчдийнхээ дансанд байршуулжээ.

“Гермес центр” компанийн хувьд ногдол ашгаа жилд хоёр удаа хуваарилдаг ба 2018 оны сүүлийн хагас жилийн цэвэр ашгаас нийт 298.5 сая төгрөгийг хувьцаа эзэмшигчдэдээ тараажээ. Харин “ЛэндМН ББСБ” ХК компани нийт 3,903 хувьцаа эзэмшигчдийнхээ 180 сая төгрөгийн ногдол ашийг 3-р сарын 28-ны өдөр байршуулсан талаар ҮЦТХТ мэдээллээ.

Эх сурвалж: BloombergTv.mn

МХБ: III сард нийт арилжааны 80 хувийг багцын арилжаа бүрдүүлсэн

3-р сард Монголын Хөрөнгийн биржээр дамжуулан нийт 26.9 тэрбум төгрөгийн үнэт цаас арилжигджээ. Энэ нь хоёрдугаар сарын үзүүлэлтээс хоёр дахин өндөр байгаа юм. 3-р сард хийсэн нийт арилжааны 80 хувь буюу 21.5 тэрбум төгрөг нь багцын арилжаа байжээ.

Үүнээс, “Хөвсгөл алтан дуулга” компанийн нийт хувьцааны 8.2 хувийг 1.3 орчим тэрбум төгрөгөөр арилжсан байна. 3-р сард тус компанийн нэгж хувьцааны ханш энгийн арилжаагаар 900 орчим төгрөгт хэлбэлзэж байсан бол багцын арилжаагаар 979 төгрөгөөр үнэлэгдсэн ажээ.

Мөн АПУ компанийн нийт хувьцааны 2.4 хувь 18.5 тэрбум төгрөгөөр арилжигджээ. Тус компанийн хувьцаа хоёрдогч зах зээлд дунджаар 627 төгрөгөөр арилжигдаж байсан боловч багцын арилжаа 720 төгрөгөөр хийгдсэн байна.

Эдгээр хоёр компани 2018 оны цэвэр ашгаасаа хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлээд байгаа билээ.

3-р сарын үнэт цаасны арилжааг харвал 3.9 тэрбум төгрөгийг хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаа, 1.4 тэрбум төгрөгийг Засгийн газрын үнэт цаасны арилжаа бүрдүүлж байна.

Түүнчлэн, 3-р сард Монголын Үнэт цаасны биржээр дамжуулан нэг сая төгрөгийн хувьцаа арилжигджээ. “Анд энерги” компанийн хувьцааны арилжааны идэвх нэлээдгүй сулраад байсан ч компанийн шинэ үйлдвэрийн нээлтээс хойш хувьцааны идэвх нь бага багаар сэргэж байгаа аж. “Анд энерги” ХК-ийн хувьцааны ханш сүүлийн нэг сарын хугацаанд 32.5 хувиар өсөж, 53 төгрөг хүрээд байгаа юм.

Эх сурвалж: BloombergTv.mn



Хонг Конгийн хөрөнгийн зах зээл үнэлгээгээрээ Японыг давж, дэлхийд гуравдугаарт бичигдэж эхэллээ

Хонг Конгийн хөрөнгийн зах зээл үнэлгээгээрээ Японыг давж, дэлхийн гурав дахь том хөрөнгийн зах боллоо.

Ингэснээр АНУ, БНХАУ-ын хөрөнгийн зах зээлийн араас бичигдэж эхэллээ. Мягмар гарагийн байдлаар Хонг Конгийн хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 5.78 их наяд ам.доллар байгаа нь Японы хөрөнгийн зах зээлээс 20 тэрбум ам.доллаар давсан үзүүлэлт болж байна. Хонгконгийн Hang Seng индекс он гарснаас хойш 17 хувиар өсөхөд “Tencent” компанийн хувьцааны ханш 22 хувиар өссөн явдал голлон нөлөөлжээ. Харин Японы Topix индекс 8.3 хувиар өсөж хаагдав.

Эх сурвалж: BloombergTv.mn

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

“Mongolian Mining Corporation”-ийн үнийн саналыг бонд эзэмшигчдийнх нь 96.46 хувь хүлээж авлаа

“Mongolian Mining Corporation” 2022 онд хугацаа нь дуусах 412.5 сая ам.долларын бонд эзэмшигчдэдээ үнийн саналаа хүргүүлээд байна. Эхний төвлөсөн хугацаа дуусах үед 96.46 хувь буюу 397.8 сая ам.долларын бонд эзэмшигчид нь үнийн саналыг хүлээж авчээ.

Өнгөрсөн долоо хоногт тус компани 2017 онд гаргасан 194.9 сая ам.долларын үнэт цаас эзэмшигчдэдээ үнийн саналаа хүргүүлсэн юм. 12.24 хувь буюу 23.9 сая ам.долларын үнэт цаас эзэмшигчид нь компанийн саналыг хүлээж авсан аж. “Mongolian Mining Corporation” санхүүгийн бүтцээ шинэчлэхээр зорьж байна. Тиймээс 2024 онд хугацаа нь дуусах 440 сая ам.долларын 9.25 хувийн хүүтэй бонд шинээр гаргажээ. Энэхүү бондын захиалга 740 сая ам.доллар болсон нь эрэлт ихтэй байсныг илтгэж байлаа. Азийн хөрөнгө оруулагчид “Өгөөж өндөр, эрсдэл ихтэй “junk bond”-уудыг их сонирхож байна” гэж “Bloomberg Intelligence”-ийн шинжээчид дүгнэжээ.

Тус компани шинэ бондоос татан төвлөрүүлсэн хөрөнгийг хуучин үнэт цааснуудынхаа төлбөрт зарцуулах юм. Баруун Наран, Ухаа худагт олборлолт хийж байгаа “Mongolian Mining Corporation”-ийн угаасан коксжих нүүрсний борлуулалт 2018 онд 9.3 хувиар өсөж, 3.9 сая тонн болсон байна. Нэг тонн нүүрсний дундаж ханш 7.2 хувиар нэмэгдэж, 139.7 ам.доллар болжээ. Хэдий тийм боловч нүүрсний ханш буурч байгаа нь эрсдэл гэж шинжээчид дүгнэж байна.

Эх сурвалж: BloombergTv.mn



Southgobi Resources: 2018 онд нүүрсний борлуулалт 1.6 дахин буурсан ч ашиг 1.5 дахин өссөн

“Southgobi Resources” компанийн нүүрсний борлуулалт 2018 онд 1.6 дахин буурч, 2.8 сая тонн болсон байна. Энэ нь Сэхэ боомтод гарсан сааталтай холбоотой гэж тус компани мэдээллээ.

Харин нэг тонн нүүрсний ханш 1.3 дахин нэмэгдэж, 37.1 ам.доллар болжээ. Үүнтэй холбоотойгоор “Southgobi Resources” компанийн ашиг 1.5 дахин нэмэгдэж, 24 сая ам.доллар болсон байна. Тус компани угаах үйлдвэрээ 2018 оны аравдугаар сард ашиглалтад оруулсан юм.

Он дуусахад 200 мянган тонн угаасан нүүрс борлуулсан байна. Цаашид угаах үйлдвэрийн үйл ажиллагаагаа сайжруулахаар ажиллаж байгаа аж. “Southgobi Resources” Монголд Овоот толгойгоос нүүрс олборлон экспортолж байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

ВI: БНХАУ-ын коксжих нүүрсний импорт 2019 онд 17.1 хувиар буурах төлөвтэй

Гол худалдан авагчдын төмрийн хүдэр, нүүрс, зэсийн импорт буурч байгаагийн улмаас Азидуул уурхайн тоног, төхөөрөмжийн борлуулалт хумигдах эрсдэлтэй байгааг “Bloomberg Intelligence” анхаарууллаа.

Энэ нь нүүрсний эрэлт буурахад мөн нөлөөлж магадгүй байна. БНХАУ-ын зах зээлийг авч үзвэл коксжих нүүрсний эрэлтийн 60 орчим хувь, зэсийн баяжмалын 50, мөн төмрийн хүдрийн 70 хувийг дангаараа эзэлдэг. Импорт нь буурвал өөрөө буулгагч ачааны машин, том оврын экскаваторын эрэлт мэдэгдэхүйц хэмжээгээр саарна гэж үзэж байгаа юм. БНХАУ-ын хувьд энэ онд нүүрсний дотоодын олборлолтоо таван хувиар өсгөж, дулааны нүүрсний олборлолтын хүчин чадалаа 200 сая тонноор нэмэгдүүлэхээр төлөвлөжээ. Энэ нь нүүрсний импортод нөлөөлөхөөр байна. БНХАУ-ын дулааны нүүрсний импорт 2019 онд 3.8 хувиар, харин коксжих нүүрсний импорт нь 17.1 хувиар буурах урьдчилсан тооцоог “Bloomberg Intelligence” гаргаад байна.

Үүнээс гадна тус улсын дотоодын нүүрс тээврийн хүчин чадал 2020 он гэхэд 30 гаруй хувиар өсөж, 2.8 тэрбум тоннд хүрэх төлөвтэй байна. БНХАУ, Энэтхэг, БНСУ гэсэн зах зээлүүдэд эрчим хүчний нүүрсний эрэлт буурч байгаа нь ачаа тээврийн салбарт мөн эрсдэл учруулна гэж харж байна. Эрчим хүчний нүүрсний эрэлтийн тухайд БНХАУ дэлхийд нэгдүгээрт, Энэтхэг хоёрдугаарт, БНСУ дөрөвдүгээрт ордог бөгөөд гурван улс нийлээд далайгаар тээвэрлэж байгаа нүүрсний эрэлтийн 50 хувийг эзэлдэг.

БНСУ өнгөрсөн онд дэлхийн нүүрсний эрэлтийн 11 хувийг дангаараа бүрдүүлсэн бол энэ онд Засгийн газраас хэрэгжүүлж байгаа нүүрсний хэрэглээг багасгах бодлогын хүрээнд импортоо бууруулах төлөвтэй байна. Харин Энэтхэгийн үндэсний компани “Coal India” 2019 оны борлуулалтын зорилтдоо хүрэх төлөвтэй байгаа аж. Тиймээс гаднаас нүүрс импортлон авахаа багасгаж магадгүй байгаа юм.

Эх сурвалж: BloombergTv.mn

Xanadu Mines: “Хармагтай” ордын ил уурхайн судалгаагаар эрдэсжилтийг нь баталгаажууллаа

Австралийн Хөрөнгийн биржид бүртгэлтэй “Xanadu Mines” компани “Хармагтай” ордын ил уурхайн судалгааг хийж дуусгалаа.

Үүгээр порфир зэсийн эрдэсжилт өндөр байгааг баталгаажуулжээ. Мөн тус компани цаашид нэмэлт өрөмдлөгүүд хийх юм байна. Энэхүү мэдээлэлтэй зэрэгцээд Австралийн Хөрөнгийн биржид хувьцааных нь ханш 0.11 австрали доллар болжээ. “Xanadu Mines” компани 4-р сарын 30-нд жил тутмын уулзалтаа хийхээр төлөвлөж байгаа аж. “Xanadu Mines” компанийн бэлэн мөнгөний үлдэгдэл 5.2 сая австрали доллар байна. Өнгөрсөн онд хаалттай хүрээнд хувьцаа гаргаж, 10 сая австрали доллар татан төвлөрүүлжээ. Тус компани 2019 онд хайгуулын ажлаа үргэлжлүүлэхийн тулд санхүүжилт шаардагдахаас гадна хамтрах түнш хайж магадгүй гэдгээ жил тутмын тайландаа дурдсан юм.

Эх сурвалж: BloombergTv.mn

БУСАД МЭДЭЭ

ҮСХ: 2019 оны 3-р сарын Монголын эдийн засгийн хураангуй

Мөнгө, зээл, үнэт цаас

Мөнгөний нийлүүлэлт (M2) 2019 оны 3 дугаар сарын эцэст 19.7 их наяд төгрөг болж, өмнөх сараас 112.4 (0.6%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 3.6 (22.5%) их наяд төгрөгөөр тус тус өссөн байна.

Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө 2019 оны 3 дугаар сарын эцэст 897.8 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 43.7 (5.1%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 57.4 (6.8%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2019 оны 3 дугаар сарын эцэст 17.5 их наяд төгрөг болж, өмнөх сараас 223.1 (1.3%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 3.3 (23.5%) их наяд төгрөгөөр өссөн байна.

Төгрөгийн америк доллартай харьцах, Монголбанкны нэрлэсэн дундаж ханш 2019 оны 3 дугаар сард 2,632.51 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 9.9 хувиар суларч, өмнөх сараас 0.03 хувиар чангарсан байна.

Төгрөгийн юаньтай харьцах, Монголбанкны нэрлэсэн дундаж ханш 2019 оны 3 дугаар сард 392.31 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 3.5 хувиар, өмнөх сараас 0.4 хувиар тус тус суларчээ.

Улсын нэгдсэн төсөв

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээ 2019 оны эхний улирлын урьдчилсан гүйцэтгэлээр 2,163.4 тэрбум төгрөг, зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 1,969.1 тэрбум төгрөг болж, тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 194.3 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа.

Төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2019 оны 3 дугаар сард 709.1 тэрбум төгрөгт хүрч, өмнөх сараас 54.7 (7.2%) тэрбум төгрөгөөр буурч, нийт зарлага, цэвэр зээлийн хэмжээ 816.8 тэрбум төгрөгт хүрч, 222.7 (37.5%) тэрбум төгрөгөөр өсжээ.

Улсын нэгдсэн төсвийн орлогын 81.0 хувийг татварын орлого, 7.9 хувийг татварын бус орлого, 10.5 хувийг ирээдүйн өв сангийн орлого, 0.6 хувийг тогтворжуулалтын сангийн орлого эзэлж байна.

Улсын нэгдсэн төсвийн зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт дүнд урсгал зардал 91.5 хувь, хөрөнгийн зардал 8.5 хувийг эзэлж байна.

Төлбөрийн тэнцэл

Төлбөрийн тэнцлийн урсгал ба хөрөнгийн дансны тэнцэл 2019 оны эхний 2 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 226.7 сая америк долларын алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеэс 99.0 сая америк доллараар буурчээ.

Урсгал данс 241.1 сая америк долларын алдагдалтай гарахад үйлчилгээний тэнцэл 382.2 сая америк доллар, анхдагч орлогын данс 116.3 сая америк долларын алдагдалтай гарсан нь голлон нөлөөлсөн байна.

Хөрөнгийн данс 2019 оны эхний 2 сард 14.4 сая америк долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 5.4 (59.9%) сая америк доллараар өссөн байна.

Харин санхүүгийн дансны тэнцэл 286.5 сая америк долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 228.6 сая америк доллараар өсжээ.

Төлбөрийн тэнцэл 2019 оны эхний 2 сард 182.1 сая америк долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 247.5 сая америк доллараар өссөн байна.

Гадаад худалдаа

Монгол Улс 2019 оны эхний улиралд дэлхийн 120 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 3.1 тэрбум америк доллар, үүнээс экспорт 1.8 тэрбум америк доллар, импорт 1.3 тэрбум америк долларт хүрлээ. Харин 2019 оны 3-р сард экспорт 678.0 сая америк долларт, импорт 448.2 сая америк долларт хүрч, өмнөх сараас экспорт 191.7 сая америк доллароор, импорт 114.7 сая америк доллароор тус тус өссөн байна.

Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 444.5 (17.0%) сая америк доллар, үүнээс экспорт 289.3 (19.5%) сая америк доллароор, импорт 155.3 (13.7%) сая америк доллароор тус тус өссөн байна.

Гадаад худалдааны тэнцэл 2018 оны эхний улиралд 351.9 сая америк долларын ашигтай гарч байсан бол 2019 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 134.0 сая америк доллароор өсөж, 485.9 сая америк долларт хүрчээ. Гадаад худалдааны тэнцэл 2019 оны 3-р сард 229.8 сая америк долларын ашигтай гарч, өмнөх сараас 77.0 сая америк доллароор өссөн байна.

Үнэ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 3-р сард улсын хэмжээнд өмнөх сараас 0.7 хувь, өмнөх оны эцсээс 1.8 хувь, өмнөх оны мөн үеэс 6.7 хувиар өссөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 3-р сард өмнөх оны мөн үеэс 6.7 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 8.2 хувь (мах, махан бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 20.5 хувь, согтууруулах бус ундааны дэд бүлгийн үнэ 6.2 хувь, сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөгний дэд бүлгийн үнэ 3.1 хувь), согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 4.1 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 4.9 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 8.7 хувь (цахилгаан, хийн болон бусад түлшний дэд бүлгийн үнэ 9.3 хувь), эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 9.9 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 3-р сард өмнөх оны эцсээс 1.8 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 6.5 хувь (мах, махан бүтээгдэхүүн 15.1 хувь), согтууруулах ундаа, тамхины бүлэг 1.3 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 1.7 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК хариуцлага хүлээхгүй болно.